



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 05 сарын 02 өдөр

Дугаар А/Р6

Улаанбаатар хот

Баянгол дүүргийн 164 дүгээр
цэцэрлэгийн данс бүртгэлээс
эргэлтийн бус хөрөнгө хасах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2019 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 3,339,200 /гурван сая гурван зуун гучин есөн мянга хоёр зуун/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж данс бүртгэлээсээ хасахыг Баянгол дүүргийн 164 дүгээр цэцэрлэг /Б.Нэргүй/-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй эргэлтийн бус хөрөнгөнөөс 1 нэр төрлийн 2,059,200 /хоёр сая тавин есөн мянга хоёр зуун/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу устгах, 1 нэр төрлийн 1,280,000 /нэг сая хоёр зуун наян мянган/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Өмчийн ашиглалт, удирдлагын газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийхийг Баянгол дүүргийн 164 дүгээр цэцэрлэг /Б.Нэргүй/-т үүрэг болгосугай.

3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг үнэлж, худалдан борлуулах ажлыг зохион байгуулахыг Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтэс /Н.Раднаасэд/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтэс /М.Энхболд/-т тус тус даалгасугай.


ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



ОЧ ОДНАСАН

115050000335

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын
 газрын даргын 2019 оны 05...сарын
 07 өдрийн 16 дугаар тушаалын хавсралт



Актлах эргэлтийн бус хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Баянгол дүүргийн 164-р цэцэрлэг

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Бүгд үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ-ийн дүгнэлт	НӨХГ-ын мэргэжилтний дүгнэлт	ЭБХХК-н шийдвэр
1	Бетондсон явган зам, талбай	47	м2	858	2,400.0	2,059,200.0	2,059,200.0	-	барилгажих талбайд орсон	актлах	устгах	устгах
2	Гэрэлтүүлгийн шон	47	ш	8	160,000.0	1,280,000.0	1,280,000.0	-		актлах	татах	татах
Нийтийн эзэмшлийн эд хөрөнгийн дүн						3,339,200.0	3,339,200.0	-				
Үүнээс : Худалдах хөрөнгө												
Устгах хөрөнгө						2,059,200.0	3,339,200.0	-				
Татан төвлөрүүлэх хөрөнгө						1,280,000.0	1,280,000.0	-				
Худалдсанаас олох орлого												
НӨХГ-т төвлөрүүлэх /30%/												